

Санхүүгийн зохицуулах хорооны 7 дугаар сарын 27-ны өдрийн
244 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн
хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, түүнд хяналт тавих
зохицуулалтын журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН МЭДЭГ ДЭЛ

Компанийн нэр	Алтайн зам ХК
Хаяг, утас	Ховд аймаг, Жаргалант, Баатархайрхан баг, 70172238
Хурал хуралдах өдөр цаг	2017.04.14-ний 16:00 цаг
Хурал зарлагч	ТУЗ
	ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал шаардлага гаргасан / нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан / нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2017.03.06
Олон нийтэд зарлах огноо	2017.03.10
Бүртгэлийн өдөр	2017.03.24
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер деллирийн компанид хүргүүлэх огноо	2017.03.15
Хүргүүлсэн огноо	
Хурлын даргын нэр	М.Нямдаваа
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Г.Сономжамц С.Баянмөнх Т.Мөнгөнцацрал
Баримт бичгийн жагсаалт / хавсралтаар/	ТУЗ2017002 тоот тогтоол ТУЗ2017003 тоот тогтоол ТУЗ2017004 тоот тогтоол 2016 оны Санхүүгийн тайлан 2016 оны үйл ажиллагааны тайлан Хөндлөнгийн аудитын дүгнэлт Шинэлчилсэн дүрмийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо ширхэг .. 3 хуудас

ХУРАЛ ЗОХИОНБАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



..... / Г.СОНОМЖАМЦ/

2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр

Дээрхи мэдээгдлийг хавсралт материалын хамт 2 хувь үйлдээж Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус ирүүлнэ.



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017.03.06

№ ТУЗ2017004

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 03 сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 60.1 дэх заалт, 76 дугаар зүйл, 76.1.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 сарын 14-ний Баасан гарагийн 16 цагт Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд хуралдуулахаар товловсугай.

ХОЁР. Хурлаар хэлэлцэх асуудал болон хуралдааны дэгийг Тогтоолын хавсралт №1-ээр батласугай.

ГУРАВ. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Нямдавааг томилсугай.

ДӨРӨВ. Хурал зохион байгуулах болон тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй батласугай.

- | | |
|-------------------|--------------------------------|
| ➤ Комиссын дарга | Г.Сономжамц/ Хараат бус гишүүн |
| ➤ Комиссын гишүүн | Т.Мөнгөнцацрал/ ТУЗНБД |
| ➤ Комиссын гишүүн | С.Баянмөнх/ ТУЗ-ийн гишүүн |

ТАВ. Хуралд оролцох эрхтэй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөр тасалбар болгож, олон нийтэд 2017 оны 03 сарын 10-ны өдөр мэдээлсүгэй.

ЗУРГАА. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл өгөх, хавсралт №2-д заагдсан баримт бичигтэй танилцуулах ажлыг Алтайн Зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд 2016 оны 3 сарын 27-ны өдрөөс 2016 оны 3 сарын 28-ны өдрүүдэд 10:00-18:00 цагийн хооронд зохион байгуулахыг комисст даалгасугай.

ДОЛОО. Санал авах хуудасны загварыг тогтоолын хавсралт №3-д зааснаар батлаж, Хувьцаа эзэмшигчдийг эчнээ санал өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулахыг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд үүрэг болгосугай.

НАЙМ. Эчнээ саналын хуудас хүлээн авах өдрийг тогтоолын тавдугаарт заасан өдөр эхлүүлж, 2017 оны 4 сарын 10-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

ЕС. Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу түгээхийг ТУЗНБД Т.Мөнгөнцацралд даалгасугай.

АРАВ. Хурлын материалыг бэлтгэн хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллахыг Комисст даалгасугай.

АРВАН НЭГ. Хуралтай холбоотойгоор гарах зардлыг Компаниас гаргахыг Алтайн зам ХК-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.НЯМДАВАА



ХУВЬЦАА ЭЗЭМШИЧГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТОВ

№	Хэлэлцэх асуудал	Хариуцан танилцуулах, гүйцэтгэх хүн	Шийдвэрийг төсөл	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх Ирцийг танилцуулах	ТУЗНБД Т.Мөнгөнцацрал		16:00-16:30
2	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон дэгийг танилцуулах	Хурлын дарга М.Нямдаваа		16:30-16:35
3	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт	ТУЗ-ийн гишүүн С.Баянмөнх	ХЭ2017001	16:35-17:35
4	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухй тогтоол	ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэг		
5	ТУЗ-ийн 2016 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай	ТУЗ-ийн дарга М.Нямдаваа	ХЭ2017002	
6	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай	Нэр дэвшүүлэх хорооны дарга С.Баянчулуун	ХЭ2017003	
7	Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай	ТУЗ-ийн дарга М.Нямдаваа	ХЭ2017004	
8	Охин компани үүсгэн байгуулах тухай	ТУЗ-ийн гишүүн С.Балжинням	ХЭ2017005	
8	Санал хураалт			17:35-17:50
9	Тооллогын комиссын тогтоол танилцуулах			17:50-18:00
10	Хурлыг хаах			18:00-18:10

ТУЗ2017004 тоот тогтоолын хавсралт №2



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. 2016 оны санхүүгийн тайлан
2. 2016 оны үйл ажиллагааны тайлан
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт
4. 2016 оны ТУЗ-ийн тогтоолууд
5. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. ТУЗ-ийн зардлын төсөв
8. Ногдол ашиг тараах эсэх тухай
9. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга
10. 2016 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоол
11. Шинэчилсэн дүрмийн төсөл



ТУ32017004 тоот тогтоолын хавсралт №3

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС

1. Хувьцаа эзэмшигчийн овог _____
2. Хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр _____
3. Хувьцаа эзэмшигчийн нэр _____
4. Итгэмжлэлээр оролцож байгаа бол төлөөлөгчийн мэдээлэл _____
5. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар _____
6. Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар _____
7. Санал өгөх хувьцааны тоо _____
8. Бүртгэсэн/ брокер, диллер/ компанийн нэр _____
9. Брокерын овог, эр _____

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	ХЭ2017001 2016 оны санхүүгийн тайлан дүгнэх тухай			
2	ХЭ2017002 2016 оны үйл ажиллагааны тайлан дүгнэх тухай			
3	ХЭ2017003 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай			
4	ХЭ2017004 Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай			
5	ХЭ2017005 Охин компани үүсгэн байгуулах тухай			

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ _____ / _____ /

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

Санал авах хуудсын ашиглах санамж

- Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсаар саналаа урьдчилан илгээж болно.
- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсан дахь тохирох хэсэгт + тэмдэглэл хийх бөгөөд нэг асуудалд нэг тэмдэглэгээ хийнэ.
- Засварласан болон балласан саналын хуудас хүчингүйд тооцогдно.
- Ээлжит хурлын талаархи мэдээллийг 976-70112251, 99155646, 99110374 тоот дугаарын утаснаас авах боломжтой

Саналын хуудас хүчингүй болсон тухай тэмдэглэл (шалтгаан) _____



Өдөр тутмын хэвлэлдр өгөх зарын төсөл

АЛТАЙН ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Алтын Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 17-ний Баасан гарагийн 16:00 цагт Алтайн зам ХК-ийн Улаанбаатар хот дахь оффисын байранд зохион байгуулагдна.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж, Алтан тариа ХК-ийн байрны баруун талд

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр 2017.03.24

Хурлаар хэлэлцэх асуудлууд

- Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт
- Ногдол хуваарилахгүй байх тухай тогтоолын танилцуулга
- ТУЗ-ийн 2016 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай
- Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай
- Охин компани үүсгэн байгуулах тухай

Хурлын материал болон, шийдвэрийн төсөл холбогдох бусад баримттай ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд 99155646 дугаарын утсанд холбогдож авах боломжтой бөгөөд 2016 орны 03 сарын 27-28-ны өдрүүдэд өөрийн байран дээр хурлын материал холрбогдох баримт бичигтэй танилцах бүрэн боломжтой.

Холбоо барих

Зохион байгуулах комиссын дарга: 99110374

ТУЗНБД 99155646

Цахим хуудас: www.altainzam.mn



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017.03.06

№ ТУЗ2017003

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 3 сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1; 46.5 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтээр Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангаагүй байх тул 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.

ХОЁР. Тогтоолыг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.6 дахь заалтын дагуу 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн Н.Энхцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017.03.06

№ ТУЗ2017002

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ДҮГНЭХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 03 сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.11 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Алтайн Зам ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагын танилцуулсан тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХОЁР. Алтайн зам ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ГУРАВ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн гишүүн С.Баянчулуунд даалгасугай.

ДӨРӨВ. Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөсөн болон тогтоосон цаг хугацаанд үнэн зөвөөр тайлагнан, журмын дагуу НББ-д тусган ажиллахыг Алтайн зам ХК / Б.Энхбат, Э.Өлзийхутаг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.НЯМДАВАА

9

АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:	2017.03.06	
Эхэлсэн цаг:	09:10	
Дууссан цаг	09:55	
Хаана:	Улаанбаатар хот. СХД 4-р хороо, “Алтайн Зам” ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	<input checked="" type="checkbox"/> Ээлжит хурал	<input type="checkbox"/> Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	<input type="checkbox"/> ирсэн	<input checked="" type="checkbox"/> ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
8	Т.Мөнгөнцацрал	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	<input checked="" type="checkbox"/> ирсэн	<input type="checkbox"/> ирээгүй

М.Нямдаваа: Хуралдаа хүрэлцэн ирсэн гишүүдэд баярлалаа. Энэ удаагийн хурлаар дараахи асуудлуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТУЗНБД Т.Мөнгөнцацрал: Хэлэлцэх асуудлын тов болон хурлын дэгийг танилцуулав.

	Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Танилцуулах этгээд
1	1. Алтайн Зам ХК-ийн 2016 оны санхүү болон үйл ажллагааны тайланг дүгнэх 2. Ногдол ашиг хуваавилах эсэх тухай 3. Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	ТУЗ2017002 ТУЗ2017003 ТУЗ2017004	Т.Мөнгөнцацрал

М.Нямдаваа: Гишүүдэд хэлэлцэх асуудлын талаар урьдчилан танилцуулсан байгаа тул тодруулах зүйлсээ асуугаад саналаа хураах нь зүйтэй байна. Гишүүдэд санал байгаа юу?

Ц.Ганцэцэг: Өмнө нь танилцсан. Нөхцөл байдлыг мэдэж байгаа. Иймд Т.Мөнгөнцацрал товчхон тайлцуулах нь зүйтэй байна.

Т.Мөнгөнцацрал: Алтай Зам ХК-ийн Санхүү болон үйл ажиллагааны тайланг та бүхэнд хүргүүлсэн багаад тэгэхээр хангалттай эсэх дээр шууд санал хураамаар байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хөрөөноос компанийн дүрмийг шинэчлэн батлахыг даалгасан албан даалгавар ирсэн. Үүнтэй уялдуулаад дүрмийн шинэчилсэн төслийг танилцуулсан байгаа.

Н.Энхцэцэг: Миний хувьд татгалзах зүйл алга. Тогтоолын төсөлтэй танилцсан байгаа. Бусад Гишүүдэд асууж тодруулах зүйл байгаа юу.

С.Баянчулуун: Жил болгон хэлэлцэх асуудал адилхан байгаа. Харин энэ жил хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд дүрэм болон охин компани нээх тухай асуудал орсон гэж ойлгож байгаа. Дүрмийг ХЭХ болох өдөр хүртэл Хувьцаа эзэмшигчид нээлттэй хэлэлцэнэ гэж ойлгоод байгаа. Ногдол ашиг мөн хуваарилах түвшинд хүрээгүй байна гэж дүгнэж байна.

С.Баянмөнх: Зөв. Тогтоолын биелэлтийг хянаад эргээд ТУЗ-д тайлангах эзэн заавал хэрэгтэй.

Т.Мөнгөнцацрал: Ногдол ашигийн тухай хуваарилахгүй байхаар байгаа. Тогтоолын биелэлтийг эргэн танилцуулах тал дээр тогтоол тус бүр дээр хариуцах эзэн тодорхой байгаа. Дүрмийн хувьд зөвхөн төслийн хэмжээнд явж байгаа. Хувьцаа эзэмшигчид саналаа өгөөд шийдэрлэх байгаа.

М.Нямдаваа: Гишүүдэд нэмж асуух, тодруулах зүйл байхгүй бол санал хураалтыг эхлүүлэе.

Гишүүдэд нэмж асуух зүйл байхгүй гэснээр тогтоолын төслийг батлах тухай санал хураалтыг эхлүүлэв.

Санал хураалтыг саналын хуудсаар авав.

ТУЗНБД Т.Мөнгөнцацрал санал хураалтын дүнг танилцуулав.

Хэлэлцэх асуудал	Шийдвэрийн төсөл	Татгалзсан	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн
1. Алтайн Зам ХК-ийн 2016 оны санхүү болон үйл ажллагааны тайланг дүгнэх	ТУЗ2017002	0	9	0
2. Ногдол ашиг хуваавилах эсэх тухай	ТУЗ2017003	0	9	0
3. Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	ТУЗ2017004	0	9	0

Т.Мөнгөнцацрал: Хэлэлцэж буй асуудалд Б.Бат-рээдүй, урьдчилан санал илгээсэн байна. Хуралд ороцсон 8 гишүүний санал, урьдчилан өгсөн 1 санал нийт 9 санал тооллоо.

Шийдвэрлэсэн нь:

Гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ2017002, ТУЗ2017003, ТУЗ2017004 тоот төгтөөлын төслийг батлаж, СЗХ болон МХБ ХК-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

М.Нямдаваа: Хэлэлцэх асуудал үүгээр дууслаа. Хуралд ирсэн гишүүддээ баярлалаа. Гишүүдэд өөр санал байгаа юу.

Гишүүдэд санал байхгүй гэснээр хурал 09:55 цагт өндөрлөв.

Хуралдааны тэмдэглэлд санал хураалтын хуудсыг хавсаргав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗНБД



Т.МӨНГӨНЦАЦРАЛ

ХЯНАСАН

ТУЗ-ИЙН ДАРГА



М.НЯМДАВАА

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



С.БАЯНМӨНХ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



С.БАЯНЧУЛУУН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



Н.ЭНХЦЭЦЭГ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



Г.СОНОМЖАМЦ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



С.БАЛЖИННЯМ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



Г.ГАНЦЭЦЭГ

